



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 498

Улаанбаатар хот

┌ Хорооны 2013 оны 249, 250 дугаар тогтоолоор ┐
батлагдсан журам, шаардлагад нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дор дурьдсан агуулгатай 3.2.13¹, 3.2.13² дахь заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 13¹, 13² дахь заалт:

Баганын дүн	1	2	3
3.2.13 ¹ . МХБ-ийн “А” самбарын компанийн хувьцаа /энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10%-иас дээшгүй байна/	10%	5%	30%
3.2.13 ² . Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	5%	1%	5%

2. Мөн журмын нэгдүгээр хавсралт “Маягт-1”-ийн “.....” ХХК-ийн 20... оны ... дүгээр улирлын зөвшөөрөгдөхгүй хөрөнгийг тооцох аргачлал”-д дор дурьдсан агуулгатай 13¹, 13² дахь мөрийг тус тус нэмсүгэй:

Баганын дүн	1	2	3	4	5	6	7=2+4+6
13 ¹ . МХБ-ийн “А” самбарын компанийн хувьцаа /энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10 %-иас дээшгүй байна/	10%		5%		30%		
13 ² . Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	5%		1%		5%		

000861

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 250 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын компанийн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурьдсан агуулгатай 5.1.8, 5.1.9 дэх заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8, 9 дэх заалт:

Баганын дүн	1
5.1.8. МХБ-ийн “А” самбарын компанийн хувьцаа /энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10%-иас дээшгүй байна/	10%
5.1.9. Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	5%

4. Мөн журмын хавсралт “Маягт-1”-ийн “Даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгө оруулалтын тайлан”-д дор дурьдсан 8, 9 дэх мөрийг тус тус нэмсүгэй:

Баганын дүн	1	2	3
8. МХБ-ийн “А” самбарын компанийн хувьцаа /энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10%-иас дээшгүй байна/	10%		
9. Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	5%		

5. Энэ тогтоолыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

6. Тогтоолоор баталсан нэмэлтийг журам, шаардлагад тусгаж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН